



Бүртгэл, хяналт, үнэлгээний
итгэмжлэгдсэн хөндлөнгийн байгууллага
**“СИТИКО-АУДИТ” ХХК-ИЙН
ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ САЛБАР**

Дархан-Уул аймаг, “Монгол Алт” ХК-ийн байр.
1 давхар 115 тоот
Утас: 99862066

Website: <http://www.siticoaudit.mn>
E-mail: batjargalsaihan@yahoo.com, citico@mongol.net

2015.02.06 № 26
таний —-ны № —-д

АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Ситико Аудит ХХК-ний Дархан уул аймаг дахь салбар нь Сэлэнгэ аймгийн Аудитын газрын 2014 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн урьдчилсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэсэн болно.

Үүрэг хариуцлагын талаархи мэдэгдэл:

Тус газар нь санхүүгийн тайлангаа Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Монгол Улсын Сангийн сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам, зааврын дагуу хугацаанд нь үнэн зөв гаргах үүрэгтэй. Энэхүү үүрэг хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, санхүүгийн тайлангуудыг аливаа материаллаг буруу илэрхийлэлгүйгээр бэлтгэх, үнэн зөвөөр толилуулахтай холбоотой дотоод хяналтыг хэрэгжүүлэх зэрэг багтана.

Тухайн санхүүгийн тайлан УСНББОУС, МУ-ын НББ-ийн тухай хууль, Сангийн Сайдаас баталсан нягтлан бодох бүртгэл, тайлагналын заавар журмын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Аймгийн аудитын газрын үүрэг юм.

Аудитын санал, дүгнэлтийн үндэслэл:

Бид аудитаа Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний Аудитын газраас гаргасан санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн билээ. Эдгээр стандарт, гарын авлага нь санхүүгийн тайлан материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитаар санхүүгийн тайлан дах дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлсийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, баримталсан бодлого, хийсэн чухал тооцоолол, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг юм.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорилоор олж авсан нотлох зүйлс нь санхүүгийн тайланд дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА
ТАНАА

Зөрчилгүй санал дүгнэлт:

Бидний санал дүгнэлтээр Сэлэнгэ аймгийн Аудитын газрын 2014 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлангууд нь УСНББОУС-д нийцуулж Сангийн сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам, зааврын дагуу материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн байна.

